

«ШАР ТУУЖ» ДАХЬ ЦОЛ НЭРИЙН УТГА

Сэнгээгийн БАДАМЦЭЦЭГ*

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл, доктор (Ph.D)

Хураангуй: Судалгааны удиртгал хэсэгт хүний нэрийн зүйд багтах их нэр, цол нэр, өргөмжлөл нэр, хоч нэр, ажил мэргэжлийн нэр, авгайлга нэрийн тухай товч, ерөнхий өгүүлсэн бол судалгааны гол хэсэг болох цол нэрд төр, шашин, бөхийн холбогдолтой нийт 39 зүйл нэр томъёог ангилан жагсааж, тус бүрд үгийн гарал үүсэл, орчуулга, үгийн сангийн утгыг тайлбарлав.

Төрийн цол нэрд хаан, хан, хатан, чинсан, ноён, тайш, тайбу, тайбужин, тайх, даюу, иш, ван, гүн, гүнван, бэйл, бэйс, тайж, бэхи, бэйж, жонон, хошууч, занги, зайсан, засаг, чөөхүр, баатар, хонжин, үйзэн, зэлдэн зэрэг голдуу хятад, түрэг хэлнээс гаралтай 28 зүйлийн цол нэр тэмдэглэгдсэн бол шашны цол нэрд далай лам, бандида, хамба, цорж, лам, тойн, хутагт, гүүш, гүр, цорж, убаиш зэрэг голдуу Төвөд, Санскрит гаралтай 9 зүйл цол, мөн арслан, заан гэх 2 зүйл бөхийн цол тэмдэглэгдсэн байна.

Түлхүүр үг: Шар тууж, хүний нэр, цол нэр, төрийн цол нэр, шашны цол нэр, бөхийн цол нэр

Судалгааны арга, хэрэглэгдэхүүн: Тус судалгаанд компьютер бүртгэлтийн арга, нэгтгэн дүгнэх арга, тайлбарлан тодорхойлох аргуудыг ашиглан, академич С.Чулууны эх бичгийн судалгаа хийж хэвлүүлсэн “Шар тууж”-ийн фото эх болон латин галигийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгов.

Удиртгал

Цол нэр нь хүний нэрийн зүй (антропонимика)-д багтах үгийн сангийн нэгэн судлагдахуун юм.

Монголын ард түмний түүхэн хөгжлийн үе шат бүхэнд хүний нэрийн зүйл нь тухайн нийгмийн улс төр, үзэл санаа, оюуны хөгжлийн онцлогийг ямар нэг хэмжээгээр тусгасан хэлний бодит жишээ болсоор ирсэн төдийгүй монгол хүний ертөнцийг үзэх үзэл, хэл зүйн нэн эртний ховор сонин жишээг олж мэдэх

* © С.Бадамцэцэг 2024

Email: badamtsetseg@mncea.edu.mn

боломжийг бидэнд олгодог.

Хүний нэр гэдэг ойлголтыг явцуу утгаар нь “Хүнийг анх төрөхөд оноон зүүлгэж дуудах үг” (Цэвэл, 1966: 398) гэж ойлгож болох ч өргөн утгаар нь авч үзвэл олон төрлийн нэрийг багтаасан ерөнхий ойлголт юм.

“Дуудах нэрийг эцэг эх өгдөг, дуурсах нэрийг өөрөө олдог” хэмээх монгол цэцэн үг байдаг. Үнэхээр хүн гэгч амьтан анх төрөхөд нь аав ээжийн оноож өгсөн нэрээс гадна хамт олон, ард түмэнд танигдах өөрийн онцлог шинж, алдар хүнд, байгуулсан гавьяа, эрдэм чадал, хөдөлмөр зүтгэлийнхээ үр дүнд цол нэр, хоч нэр, өргөмжлөл нэр, ажил мэргэжлийн нэр гэх мэт янз янзын нэрийг зүүж явдаг билээ. Жишээлбэл: Их бичгийн хүн Бямбын Ринчен, их зохиолч Д.Нацагдорж, Ш.Чоймаа багш, жүжигчин Цагааны Цэгмид гэх мэт олны танил хүмүүсийг бид цол нэр, өргөмжлөл нэр, хоч нэрээр нь төвөггүй таньдаг. Иймээс хүний нэрийг “их нэр буюу оноож өгсөн өөрийн нэр, бичил нэр буюу бусад олон нэр” гэж ангилж болох юм.

Энд их нэр гэдэг нь эхээс төрөхөд өгсөн дуудах өөрийн нэрийг, бичил нэр гэдэг нь цол нэр, өргөмжлөл нэр, хоч нэр, ажил мэргэжлийн нэр, авгайлга нэр, хүндэтгэл нэр, дуудлага нэр зэргийг хэлж байна.

Энэ удаагийн өгүүлэлдээ зөвхөн цол нэрийн тухай авч үзэх бөгөөд, “Шар тууж” дахь цол нэрс нь төрийн цол нэр, шашны цол нэр, бөхийн цол нэр гэсэн бүтэцтэй байна.

1. Төрийн цол нэр

Төрийн цол нэрд хаан, хан, хатан, чинсан, ноён, тайш, тайбу, тайбужин, тайх, даюу, иш, ван, гүн, гүнван, бэйл, бэйс, тайж, бэхи, бэйж, жонон, хошууч, занги, зайсан, засаг, чөхүүр, баатар, хонжин, үйзэн, зэлдэн зэрэг голдуу хятад, түрэг хэлнээс гаралтай 28 зүйлийн цол нэр тэмдэглэгджээ. Эдгээр цол нэрсийн гарал үүсэл, утга үүргийг цолын эрх мэдлийн дэс дараагаар жагсаан бичиж тодорхойлохыг зорилоо.

1.1. Хаан - (qayan) феодалын байгуулалт улсын хамгийн дээд ноёрхогч, хан буюу эзэн ч гэдэг байжээ. Хятад хэлний 皇帝 (huangdi) эзэн хаан гэдэг үгээс ирэлтэй. Уйгар, түргээр бас ‘qakan’ гэдэг.

“Шар тууж”- д Чингис хаан, Өгөдэй хаан, Гүег хаан, Гүдэн хаан, Мөнх хаан, Хубилай сэцэн хаан, Өлзийт хаан, Хүлэг хаан, Буянт хаан, Гэгээн хаан, Есөнтөмөр хаан, Хүсэл хаан, Заяат хаан, Эрэнцэнбал хаан, Тогоонтөмөр ухаант хаан, Билэгт хаан, Усгал хаан, Энхзоригт хаан, Элбэг нигүүлсэгч хаан, Гүнтөмөр хаан, Өлзийтөмөр хаан, Дэлбэг хаан, Адай хаан, Тайсун хаан, Мэркүс хаан, Молом хаан, Мандуул хаан, Батмөнх даян хаан, Бодь-Алаг хаан, Гүдэн хаан, Түмэн засагт хаан, Буян даюун сэцэн хаан, Лигдэн баатар хаан зэрэг Монголын 34 хаанаас гадна Жүрчидийн Жанжун хаан, Солонгосын Бух цагаан хаан, Хятадын Тан Ао Жин (tang ao jing) хаан, Алтан хаан, Шар сартуулын Султан хаан, Тогмутийн Мэнгүлэ хаан, Хэрэйдийн Он хаан, Найманы Таян хаан,

Горлосын Нарийн хаан, Харлагуудын Арслан хаан, Төвөдийн Хүлэгдорж хаан, Сартагчины Амбагай хаан, Минагийн Шударга хаан, Энэтхэгийн Махасамбади хаан, Намайг хөх хаан, Арслан оочит хаан, Ариун идээт хаан, Цагаан идээт хаан, Тансаг идээт хаан, Рашаан идээт хаан, Төвөдийн ургуулагч нэрт хаан, Хүзүүн сандалт хаан, Хүмүүн сандалт хаан, Шувуун сандалт хаан, Арвай сандалт хаан, Морин сандалт хаан, Алтан сандалт хаан зэрэг нийт 63 хааны нэр тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

eng terigün enedkeg-ün maq-a sambadi qayan tere buyu: [3a: 8: - 9]

küjügün sandalitu qayan tere buyu:: töbed-ün eng terigün [4a: 2]

yal morin jil-dür: qubilyan činggis qayan törüjü: [4b: 8]

1.2. Хан - (qan)

Эртний Түрэг, Сянби (шивээ), Хүй ге (Хойгур - Уйгар), Монгол зэрэг үндэстний хааны дараах чин вангаас дээш хэргэм, аймаг мужийн тэргүүн ноёд багтана. Түрэгийн ёсонд их, бага хаан гэж ялгаж байсан бөгөөд ихийг нь хаан, багыг нь хан гэдэг байжээ. Юань улсаас хойш Монголд ч ийм заншилтай байжээ. (Сэцэнцогт, 1988: 50) Жишээлбэл:

eriye-kei[=eriyekei] mergen qayan-u köbegün yombudorji tüsiyetü qan: [27b: 3]

norbu sečen qan-i[=qan-u] köbegün sonam dorji sečen qan, [30b. 6:- 8]

“Шар тууж”-д тэмдэглэсэнээр Зүчи, Цагаадайн хойч бүгд “хан” цолтой байжээ. Жишээлбэл:

činggis qayan-u yeke köbegün jöči qan-u] köbegün abdarai qan, tegünü[=tegün-ü] köbegün abul mamud qan, [31a: 19:- 23] гэх мэт.

1.3. Хатан - (qatun) хаад ноёдын эхнэрийг заах үг. Уйгар, Түрэгээр бас [hotun ~ katin ~ kadin] гэдэг. “Шар тууж”-д Чамбуй гоо хатан, Гүрвэлжин гоо хатан, Мандухай сэцэн хатан, Хүсэй хатан, Жимсгэн хатан зэрэг таван хатан цол тэмдэглэгджээ. Жишээлбэл:

qutuy-tu qubilai sečen qayan-u čambui qow-a qatun [10a. 18]

sidur yu[=siduryu] qayan gürbeljin qow-a qatun-i [7b.17]

tendeče[=tende-eče] manduqai sečen qatun-ača törügsen törü bolud, ulus bolud qoyar ikere[=iker-e]: [20a.7]

1.4. Чинсан - (čingsang) 丞相 (cheng xiang) гэдэг хятад үгийн монголжсон дуудлага. Хаан эзний туслагч хамгийн дээд сайд түшмэлийн цол. “Шар тууж”-д “чинсан” цолыг Батула чинсан, Ялаху чинсан, Алаг чинсан, Төмөр чинсан, Цагаадай чинсан зэрэг 5 чинсан цолтой хүний нэр тэмдэглэгджээ. Жишээлбэл:

batuladu[=batula-dur] cingsang čola ögčü: [13b.16]

esen tayisi-yi oyirad-un barayun yar-un alay čingsang, temür čingsang qoyar dob-
tulju [17b.20:21]
qosiyud-un uy čayadai čingsang [32b.26]

1.5. Ноён - (noyan) 1. цэрэг засгийн дээд зэргийн тушаалтан, 2. хуучин нийгэмд боол зарц бологсод эзнээ ноён гэдэг, 3. зэрэг тушаалтны хүндэтгэл, голдуу феодалын ба хөрөнгөт улсад олон хэрэглэдэг. Мөн эртний хятад хэлний 老爷 (laoye) гэдэг үгээс үүсэлтэй ч гэж үздэг. “Шар тууж”-д нийт 56 ноён цолтой хүний нэр тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

irekü bayatur noyan-i[noyan-u] köbegün saran erdeni törü-yin noyan: [22b. 7: 8]
irbes sečen noyan: irbes ede üjümečin deger-e sayuysan: [22b.10:11]
mongyol-un eng teri-gün[=terigün] noyan börte činu-a buyu: [4a.19]

1.6. Тайш - (tayisi) 太师 (tai shi) гэдэг хятад үгийн монголжсон дуудлага. Хаанд туслагч түшмэл гэсэн утгатай үг. “Шар тууж”-д Эсэн тайш, Бахму тайш (Тогоон тайш), Өөдлөх нэрт хөвгүүн (Арагтай тайш), Болой тайш, Исмэл тайш зэрэг голдуу Ойрад угсааны 6 хүний нэр тэмдэглэгджээ. Жишээлбэл:

toyun tayisi ejen-i[=ejen-ü] čayan ger-i ergičü dayari laju[=dayarilaju], [15a.1]
aruytai-du tayisi čola öggüged: adai qayan, ajai tayiji aruytai tayisi yurbayula mor-
da ju[=mordaju]: [14b.8]
oyirad-un esen tayisi-tai nigned-čü[=nignedcü] [15b.19]

1.7. Тайбу - (tayibu) 太保 (taibao) гэдэг хятад үгийн монголжсон дуудлага. Хаанд туслах тайфу (太傅) буюу хаанд туслах тайшийн дараах түшмэлийн цол нэр. Мөн хааны залгамжлагч хөвгүүн тайжийг заан сургагч гэсэн утгатай хятад үг. Бичгийн хувилбараар тайбуугаас тайбу болсон байна. “Шар тууж”-д тайбу цолтой хүн 2 тэмдэглэгджээ. Жишээлбэл:

oyirad-un ögedei tayibu yuničü yabuday bile: [17a. 26]
qonggirad-un eselei tayibu [17b.12]

1.8. Тайбужин-(tayibužin) 太福晋 (taifužin) (达夫人 dafuren) гэдэг хятад үгийн монголжсон дуудлага. Их хатан гэсэн утгатай хятад үг. “Шар тууж”-д тайбужин цолтой хүний нэр 2 тэмдэглэгджээ. Жишээлбэл:

tegüsken qow-a gergei inu böjin tayibužin čola soyurqaju: [7a.13]
solungyus-un saquldai-yin em-e qarayčin tayibužin [17a.13]

1.9. Тайх - (tayiqu) 太后 (taihou) хатан хаан гэсэн утгатай хятад үг. Бөртэ сэцэн сутай тайх, Сорхогтун бэхи тайх, Өлзийт бэйж тайх, Самар гүнж тайх,

Шихэр тайх зэрэг тайх цолтой 5 хатны нэр тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

börte sečen sutai tayiqu ügülerün: [6a.10]
 sorqaytai beki tayiqu-ača törüg-sen[=törügsen] möngke, qubilai, ülegü, ariγ böke
 dörben köbegün aysan buyu:: [9b.25]
 bolqu jinong-yin[=jinong-un] siker tayiqu [18b.25]

1.10. Даюү- (dayu) нь хятад хэлний 太尉 (tai wei) гэдэг үгийн монголжсон хувилбар ба цэрэг захирах эрхтэй түшмэлийн цол нэр. “Шар тууж”-д даюү цолтой хүний нэр 1 тэмдэглэгджээ. Жишээлбэл:

oyirad-un quuqai[qooqai] dayu ögüler-ün[=ögülerün]: [13a.2]

1.11. Эш - (esi) хатан гэсэн утгатай уйгар үг. “Шар тууж”-д эш цолтой хүний нэр 1 тэмдэглэгджээ. Жишээлбэл:

esi qatun-a: öber-iyen eyin öcirün: qara[=qar-a] čayan-i ülü üjeküi yaǰar-a berilem bile [19a.12]

1.12. Ван -(vang) нь хятад хэлний 王 (wang) гэдэг үгийн монголжсон хувилбар. Эртний монгол хэлэнд Он гэж тэмдэглэдэг. Жишээлбэл: [MNT§104] Kereyid-ün To'oril Ong_qan-tur

Сэцэнцогт бээр ван гэдэг үгийг “Чин улсын үеийн хошууны түрүү тушаал: хошууны ван, вант улсын тэргүүн тушаал: чин ван” (1988: 2493) гэж тайлбарлажээ. “Шар тууж”-д ван цолтой хүн Лигдэн хааны хоёрдугаар хөвгүүн Абнай чин вангаас эхэлж 44 ван цолтой хүний нэр тэмдэглэгджээ. Ван цолтныг дотор нь чин ван, жүн ван гэж 2 ангилж байсан бөгөөд эрэмбэ зэргийн хувьд чин ван нь эхэнд ордог байжээ. “Шар тууж” -д чин ван 3, жүн ван 10 тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

abanai čing vang [21b.22]
 sonam gueün vang [23a.7]*
 tenggis mergen vang [22a.2]

**Тайлбар: Энд жүн гэдэг үгийг gueün гэж галигласан нь эртний Хятад хэлэнд ji, qi, shi -г gi, ki гэж дууддаг байсантай холбоотой. Тодруулбал, Шар туужийн зохиолч 君王 (junwang) гэдэг үгийг 君 гэж эртний дуудлагаар бичсэн учраас gueün гэж галигласан.р-*

1.13. Гүн - (güng) 公 (gong) гэдэг хятад үгийн монголжсон дуудлага.

Феодалын байгууллын таван хэргэмийн тэргүүн зэрэг, чин улсын хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр. “Шар тууж”-д Барсболд жононгийн 5 дахь үеийн ач болох Жамц гүнээс эхлэн Соном гүн, Дүүрэн гүн зэрэг 10 гүн цолтой хүний нэр тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

jamsu güng: tegünü[=tegün-ü] köbegün sonam güng: [23a.15]
 badm-a erdeni qung tayiji-yin köbegün sayin lubsang güng: [26b.15]
 dorji joriγtu jinong: tegünü[=tegün-ü] köbegün jasi güng: [27a.1]

1.14. Бэйл - (beyile) Манж хэлний 贝勒 (beile) гэдэг үгээс гаралтай, жүрчинээр дамжиж монгол хэлэнд орсон үг гэж “Язгуурын толь”-д тэмдэглэсэн. Чин улсын ван, гүн, бэйл, бэйс хэтэрхий дөрвөн хэргэмийн гуравдугаар. Тэргүүн сайд гэх утгатай манж гаралтай үг.

Гомбо бэйл, Шанд бэйл, Сүнрэв бэйл, Бэйл Цэвдэн, Бэйл Лувсан зэрэг 14 бэйл цолтой хүн тэмдэглэгджээ. Жишээлбэл:

darmasiri-yin köbe -gün[=köbegün] lhamudorji beyile: [26b: 7: 8]
 arba tegünü[=tegün-ü] köbegün šanda beyile [23a.6:8]
 šagja beyise: tegünü[=tegün-ü] köbegün gürüs -ki[=gürüsiki] beyile [23a. 21]

1.15. Бэйс - (beyise) Манж хэлний 贝子 (beizi) гэдэг үгээс гаралтай. Чин улсын ван, гүн, бэйл, бэйс хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр. “Шар тууж”-д 13 бэйс цолтой хүн тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

sangji čögükür tegünü[=tegün-ü] köbegün šagja beyise [23a. 20]
 güüsi noyan: tegünü[=tegün-ü] köbegün erinčin beyise [23b. 1]
 gürü dayičin: tegünü[=tegün-ü] köbegün saran beyise [23b. 7]

1.16. Тайж - (tayiji) 太子 (taizi) хааны хөвгүүн, хааны ах гэсэн утгатай хятад үг. Хааны угсаатан, Юань улсын үед хааны хүүг тайж гэж байжээ, хожим нь түүний ойр угсааг цөм ингэж нэрлэх болжээ. “Шар тууж”-д тайж цолтой хүн олон байна. Хархуцаг дүүрэн хун тайж, Чингэм тайж зэрэг нийт 141 тайж цолтой хүний нэр тэмдэглэгдсэнээс 51 нь хятад хэлний 皇 (huang) хаун буюу эзэн хаан хэмээх үгтэй хамт хэрэглэгдсэн байна. “Шар тууж”-д хун тайж 28, үйзэн тайж 3, дүүрэн хун тайж 1, дархан хун тайж 3, чин хун тайж 1, дайчин хун тайж 1, сэцэн хун тайж 2, убашин хун тайж 3, баатар тайж 3, отгон тайж 2, үйзэн тайж 3, зэлдэн тайж 2, занги тайж 1, чин тайж 1, бөх тайж 2, засгийн тайж 14, бинт тайж 1 тус тус тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

gegen qayan-u yutayar köbegün töbed tayiji [24a.1: 3]
 norbu tayiji tegünü[=tegün-ü] köbegün g'aldan tayiji [24a. 4: - 6]

bayisangqur üijeng tayiji [24a. 11: -14]

1.17. Бэхи - (beki) “Бэхээс бэйж, бийж гэж хувирч ирсэн” (Сэцэнцогт, 1988: 700) гэж тэмдэглэсэн байна. “Шар тууж”-д ‘бэхи’ гэдэг үг хатан, авхай гэдэг утгаар 1 удаа тэмдэглэгдсэн байна. Жишээлбэл:

sorqaytai beki tayiqu [9b.25]

1.18. Бэйж - (beyiji) Хятадын “Сянь Юань бичиг, харь үгийн тайлбар” хэмээх толь бичигт: “Бэйж хэмээгч тайж нарын эхнэрийг хэлнэ.” гэж тэмдэглэжээ. Мөн “Асрагч нэргийн түүх” -ийн мэдээгээр “Хаан угсааны сул хатан лугаа адил хятад хэлний 妃子 (fei zi) буюу сул хатан хэмээх үгийн монгол дуудлага” (Заяабаатар, 2011:30) гэж тэмдэглэсэн байдаг. “Шар тууж”-д Өлзийт гоо бэйж, Цэцэг бэйж гэсэн 2 бэйж цолтой хүний нэр тэмдэглэгдсэн бөгөөд бэйж, бийж гэж 2 янзаар бичжээ.

öljeyitü qow-a beyiji-yin öngge gerel egünče[=egün-eče] ilegüü kemegsen [13a: 4]

seceg beyiji jaγay-yi inu qoyisi tataju sigelge- bei[=sigelgebei]: [17a: 5]

qarqačuy-un seceg biiji-eče törüg -sen[=törügsen] keüken yurban nasutai bui [17b:3]

1.19. Жонон - (jinung) 晋王 (jin wang) гэх хятад үгийн монголжсон хэлбэр. Монголын хаан эзэнд туслан засаг төр мэдэгч ноёны цол, Мин улсын үед Монголын хаанд туслан баруун гарын Монголыг мэдэгчийн тушаал байжээ. “Шар тууж”-д 17 жонон цолтой хүний нэр тэмдэглэгдсэн байна.

baras bolud jinung-yin köbegün gümeli mergen qara jinung [22b. 15: 16]

gümeli jinung-yin[=jinung-un] nigedüger köbegün, noyan dar-a jinung [22b. 20: 21]

tegünü [=tegün-ü] köbegün bosiγtu jinong [22b. 22: 24]

1.20. Хошууч - (qosiγučī) Ахлагч, манлайлагч гэсэн утгатай цол нэр. “Шар тууж”-д 13 хошууч цолтой хүний нэр тэмдэглэгдсэн байна. Жишээ нь:

ananda mergen qosiγučī[=qosiγučī]: [23a. 4]

oyidarm-a nomuqan noyan: tegünü[=tegün-ü] köbegün degei qosiγučī[=qosiγučī]: [23a.10]

baqarai qosiγučī [=qosiγučī] noyan: bodisung odqun.: [27a. 17]

1.21. Занги- (janggi) Чин улсын үеийн Монгол хошуудын цэрэг засгийн зэрэг тушаал, сумтай тэнцэнэ. Сумын занги, харуулын занги, баатар, жанжин гэсэн утгаар мөн хэрэглэдэг. “Шар тууж”-д сумын занги цолтой хүний нэр 1 удаа тэмдэглэгдсэн байна.

k'andur- Si[k'andurasi] sumun-u janggi tayiji:: [24a.5]

1.22. Хүндлүн- (kündülen) Хүнд гэдэг үгийн хуучирсан утгат “Сумын зангийн дараах албан тушаал: сумын хүнд, хошууны хүнд” (Сэцэнцогт, 1988: 624) гэж байсан байна. Иймээс “сумын зангийн дараах албан тушаал”-ыг заах “хүнд” гэх үгээс Хүндлүн хэмээх цол нэр үүссэн байж болох юм. “Шар тууж”-д хүндлүн цолтой хүн 8 тэмдэглэгдсэн.

daldan[=delden] kündülen: samu odqun [25b. 26]

časkib kündülen ubasi [28a. 26]

labuy tayiji, bayisyal kündülen qayan, [22b. 17]

1.23. Зайсан -(jayisang) Хятад хэлний 宰相 (zai xiang) гэдэг үгийн авиачилсан үг. “Юань улсын үе дэх дотоод ордны ноёны зэрэг тушаалын нэр, хожим нь голдуу хааны зарлиг бичгийг орчуулан хянах, түүх судрыг эрхлэн зохиох үүргийг хариуцдаг байжээ. Хошуу нутгийн нэгэн зүйл тушаал” гэж “Монгол үгсийн язгуурын толь”-д тайлбарлажээ. Дорж эет зайсан, Дорж номч зайсан, Цэвдэн эрх зайсан зэрэг 6 зайсан цолтой хүний нэр тэмдэглэгджээ. Жишээ нь:

dorji eyetü jayisang: [24b.3]

dorji nomči jayisang [24b.9]

čebden erke jayisang [24b. 15]

1.24. Засаг - (jasay) Чин улсын үеийн Монголын хошуу яамыг хамаарах үе залгамжлагч ноёны тушаал. “Шар тууж”-д засагт хан, засгийн тайж, чин засаг зэрэг засаг цолтой 4 хүний нэр байна.

layiqur qayan-u köbegün subundai jasaytu qayan [26a. 9]

čambun jasaytu seçen qayan [26a. 20]

dasi qung tayiji: tegünü[=tegün-ü] köbegün jasay tayiji čerin -jab[=čerinjab]: [27a. 24]

1.25. Чөөхүр- (čögükür) Судлаач Чойжи “Мянган хэгээст”-ийг харгуулан тайлбарлахдаа чөөхүр гэдэг үгийг ᠴᠣᠬᠤᠵᠢᠷ (chos khor) буюу номын хүрдэн гэсэн утгатай Төвөд үгтэй холбосноос өөр тодруулан нотолсон зүйл хараахан үгүй байна. Чойжигийн дурдаж буй ᠴᠣᠬᠤᠵᠢᠷ хэмээх Төвөд үгийг Монголчууд Чойнхор гэж хэлдэг тул Чөөхүр гэдэг үгтэй дуудлага болон бичлэгийн талаар тун их зөрөөтэй байна. Сурвалжуудад čögükür, čögekür, čökür гэж янз янзаар тэмдэглэсэн байдаг. “Шар тууж”-д Бурхай сэцэн чөөхүр, Суман ахай чөөхүр, Цэрэн чөөхүр зэрэг 6 хүний нэр тэмдэглэгдсэн байна. Жишээ нь:

kögečedei tayiji-yin köbegün buraqai čögükür [21b. 26:1]

n]akiy-a küdülen[=kündülen] dayičin: tegünü[=tegün-ü] [=köbegün] sangji čögükür:

[23a. 19]

sadaḍai[satatai] sečen cögükür [23a. 25]

1.26. Баатар - (baɣatur) Хүч чадал, цөс зоригтой бөгөөд дайнд шалгарсан гавьяатай хүнд олгох цол, Уйгар, Түрэгээр “bator”, Зүрчинээр “batoru” гэнэ. “Шар тууж”-д баатар цолтой хүний нэр 28 тэмдэглэгджээ. Жишээ нь:

darai-yin qoyaduyar köbegün üijeng baɣatur: [25a. 25]

noyandai qatan baɣatur: [25b. 23]

töbed qatan baɣatur [26b: 20]

1.27. Үйзэн - (üijeng) Хятад хэлний weijen хэмээх үгийн монголжсон хэлбэр. Энэ үгийн талаар М.Баярсайхан “Юань улсын үед ордныг хамгаалах цэргийн нэгжийг вэй гэж байжээ. Мин улсын үед Вэй гэдэг нь засаг захиргааны нэгж болсон байна. Энэ Вэйгийн нэгж Монголд ч нэвтэрсэн байна. Тухайлбал, зүүн Монголын Урайнхан нь гурван вэй байжээ. Вэйгийн захирагчийг Вэйжэн гэдэг” (2011: 756) гэж тэмдэглэсэн байна. Мөн Буяндэлгэр “16-17 дугаар зууны Монголын улс буюу түмний ноёлогчдын цолын дотор үйзэн нь зүүн гарын ноёлогчдын цол байсан бөгөөд байр суурь нь хаан, хун тайжаас доор ...” (1999: 90) гэж тэмдэглэжээ. “Шар тууж” дахь Үйзэн цолтой хүний нэрийн жишээ:

eseng üijeng noyan [24b.8]

qurqači-yin köbegün üijeng noyan [25a. 4]

qalq-a-yin subuqai üijeng [20b: 25]

1.28. Илдэн - (ilden) Сайшаал агсан үүнийг “ил+дэн гэсэн бүтэцтэй монгол үг” гэж үзсэн. Тэрээр ил гэдэг нь дундад үеийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байсан боол, зарц гэсэн үг бөгөөд “Их Монгол улсын Далай хааны тамга”-ы дардасын үгэнд гардаг “Ил хан” улс гэхэд бас гардаг гэжээ. “Ил” хэмээх үгийг Сэцэнцогт “эл”-ээс авианы хувиралтаар “ил” болсон гээд “Эе нийлэмж, эв сайн” гэх утгатай үг гэж тайлбарласан байдаг. Хятад үсгээр 银定 (yin ding) гэж галиглана. “Шар тууж”-д 𐰽𐰺𐰍 (𐰽𐰺𐰍) • 𐰽𐰺𐰍 гэж 2 янзаар бичсэн бөгөөд 𐰽𐰺𐰍 гэж бичих нь зөв.

üijeng noyan-u köbegün yelden noyan [25a.12]

bingtü tayiji, yelden tayiji, buyan-tu tayiji: [25b. 11]

jodba yelden darmasiri [26b: 3]

2. Шашны цол нэр

Шашны цол нэрд далай лам, бандида, хамба, цорж, лам, тойн, хутагт, гүүш, гүр, цорж, убаш зэрэг голдуу Төвөд, Санскрит гаралтай 9 зүйлийн цол тэмдэглэгджээ.

2.1. Тойн - (toyin) Язгууртан гаралтай лам, бумбын шашны хувраг гэсэн

утгатай Уйгар гаралтай үг. Төвөдөөр བུ་ལུ་པ་ (btsun pa) гэнэ. “Шар тууж”-д Шар охин тойн, Гүүш тойн зэрэг 10 тойн цолтой хүний нэр тэмдэглэгдсэн байна. Жишээ нь:

lubsang toyin [28b.24]

bayingjur erke jayī -sang[=jayisang] toyin boluγsan-u qoyin-a danjin toyin, [28b.3]

šamba qatan bayatur toyin boluγsan-u qoyin-a darm-a giyuba toyin [28b.9]

2.2. Бандида - (bandida) Санскритаар pandita Төвөдөөр བཤོ་ཏི་ཏ། (panti ta) гэнэ. Буддын шашны их таван ухаанд нэвтэрсэн хүнд олгох эрдмийн цол нэр. Их таван ухаан гэдэг нь дуун ухаан, урлахуй ухаан, тэжээхүй ухаан, учир шалтгааны ухаан, тогтсон тааллын ухаан эдгээрийг хэлдэг. “Шар тууж”-д бандида цолтой хүн 2 тэмдэглэгджээ.

šaki-a-yin g'ungg'a jalčan kemekū saki-a bandida kemebesü [9a.22]

erke čögükür-ün köbegün nom-un qayan qambu bandida qutuy-tu [29a. 13]

2.3. Лам - (blam-a) төвөдөөр བཤོ་མ། (phal ma) буюу эрхэм дээд их багш гэсэн утгатай. “Шар тууж”-д Ананд гарви лам, Ширибада лам, Богд шири лам, Ананд бада гэрэ лам, Пагва лам, Дагважалцан лам зэрэг 12 лам цолтой хүний нэр тэмдэглэгджээ.

čaman čögükür toyin boluγsan-u qoyin-a čögükür blam-a, [28b. 11]

saki-a-yin čen-e ločaw-a ananda g'arbi kemekū blam-a [5a. 25]

šaki-a-yin manju ghova hay-a radna kitu blam-a [10b. 17]

2.4. Хамба - (qambu) གཤམ་པོ། (gan pho) Багш гэсэн утгатай Төвөд үг. Сүм хийдийн хэргийг тэргүүлэн удирдах тушаалтны цол нэр. “Шар тууж”-д номын хаан Хамба бандида хутагт гэж 1 хүний нэр тэмдэглэгджээ.

erke čögükür-ün köbegün nom-un qayan qambu bandida qutuy-tu [29a. 14]

2.5. Убаши - (ubasi) upaska Гэртээ сахил авсан, гэлэн хүний цол нэр. Мөн “гэнэн сахил” ч гэж хэлдэг. Убсанз ч гэдэг. “Шар тууж”-д 11 убаши цолтой хүний нэр тэмдэглэгджээ.

sira[=sir-a] jasaytu qayan, g'aldan ubasi [26a. 25]

dayibung qung tayiji-yin köbegün yonbu joriγtu ubasi [26b: 5]

dayičin qotuyur-un köbegün ubasi qung tayiji [26b: 11]

2.6. Гүүш - (güüsi) 国师 (guo shi) Хятад хэлний улсын багш хэмээх утгатай энэ үгийг Төвөдөөр дамжин Монгол хэлэнд зээлсэн бололтой. Мөн орчуулагчийн цол нэр. “Шар тууж”-д 2 гүүш цолтон тэмдэглэгдсэн байна.

sadadai[satatai] sečen čögükür: tegünü [=tegün- ü] köbegün güüsi noyan [23a. 26]
čebden erke jayisang tegünü[=tegün-ü] köbegün güüsi toyin: [24b. 16]

2.7. Гүр - (gürü) ལྷུ (gu ru) Багш гэсэн утгатай Төвөд үг. “Шар тууж”-д гүр цолтон 3 байна.

güden qoluči noyan-i[=noyan-u] köbegün gürü qung tayiji [24b. 23]
čoyila jünung-yin köbegün gürü čin vang [22b. 26]
mingqai dayičin: tegünü[=tegün-ü] köbegün gürü dayičin: [23b. 6]

2.8. Цорж - (čorji) མཚོ་རྩེ་ (tshwos rje) Хамбын орлогч бөгөөд шашны сүм дацанд хурах хурал номын үйлийг орлон гүйцэтгэх ламын цол нэр. “Шар тууж”-д цорж цолтон 1 тэмдэглэгдсэн байна.

mayidari nom-un qayan, joni čorji terigüten-eče gün narin niyuča kölgen-ü abasig[=abisiy] abču [21a. 21]

2.9. Хутагт- (qutuytu) Их гэгээн хувилгаанд олгох цол. Далай банчины дараа орно. Хутаг буюу хувь зохиол, хишиг буян, амь нас гэсэн утгатай үгийн үүсмэл үг. “Шар тууж”-д хутагт цолтон 2 тэмдэглэгджээ.

bisireltü qayan-u köbe-gün[=köbegün] dayla g’aldan qutuy-tu [26a. 22]
sangg’arjai yelden qosiuči-yin[=qosiyuči-yin] köbegün ...ilayuyusan noyan qu-
tuy-tu [29b: 18]

3. Бөхийн цол нэрийн утга

3.1. Арслан - (arslan) 13-р зууны дунд үеэс эхлэн арслан хэмээх цол үүсжээ. 17-р зууны үед долоон хошууны даншиг наадамд барилдаж олон удаа түрүүлсэн бөхөд өгдөг байжээ. Одоо үед аймгийн наадамд найм ба түүнээс дээш, улсын наадамд ес ба түүнээс дээш давсан бөхөд олгодог. “Шар тууж”-д аймгийн арслан цолтой хүний нэр 1 тэмдэглэгджээ.

tümengken čoytu qung tayiji, tegüni[=tegün-ü] köbe -gün[=köbegün] včir ay-
imaγ-un arsalan [30a. 8]

3.2. Заан - (jaγan) “13-р зууны дунд үеэс эхлэн заан хэмээх цол үүссэн бөгөөд “17-р зууны үед долоон хошууны наадамд түрүүлсэн бөхөд өгдөг” (Шастиной, 1957: 191) байжээ. Одоо үед аймаг болон улсын наадамд долоо давсан бөхөд олгодог болсон. “Шар тууж”-д заан цолтой хүн 2 тэмдэглэгдсэн байна.

g'arm-a жүг-үн яayan [30a. 10]

manglai erdeni, tegünü[=tegün-ü] яayan дүгүрөнг [22a. 21]

Дүгнэлт

“Шар тууж” дахь цол нэрсийг жагсааж, нийт давтамжийн тоог гаргаж, үг тус бүрийн гарал үүсэл, үгсийн сангийн утгыг тайлбарлаж, жишээ дагалдуулав. Нийт 39 цол нэр түүвэрлэн жагсааснаас төрийн цол нэр 28, шашны цол нэр 9, бөхийн цол нэр 2 байна. Монгол, Түрэг гаралтай үг 49%, Хятад, Манж гаралтай үг 48%, Төвөд, Санскрит гаралтай үг 3% -ийг (График 1) эзэлжээ. Мөн хамгийн олон давтамжтай “тайж” гэх үг 216 удаа (График 2) илэрч байгаа нь 13-17-р зууны Монголын түүхэнд тайж цол төрийн албан тушаалын нэрээс хааны угсаа залгамжлах хөвгүүдийн нэр болтлоо нийтлэг нэр болж хэрэглэгдэж байсныг харуулж байна.

“Шар тууж” дахь нийт зээллэг үгийн дотор 56% -ийг хүний нэр голдуу Төвөд үг, 24% -ийг Санскрит үг, 20% -ийг цол нэр голдуу Хятад үг эзэлж байгаа бол нийт Санскрит үгийн 10%, Төвөд үгийн 9%, Хятад, Манж үгийн 98% нь цол нэр (График 3, 4, 5, 6) байна.

Цол нэрийн тоон үзүүлэлт



График 1

Хамгийн олон давтамжтай цол нэрс




График 2




График 3, 4, 5, 6

Abstract: In the introductory part of the research, a brief description of first names, titles, honorific names, nicknames, and occupational names included in human nomenclature is given. A total of 39 terms of state, religion, and wrestling significance were listed in the main part of the study, and the origin, translation, and vocabulary meaning of each word was explained.

State titles include king, khan, queen, chinsan, lord, taish, taibu, taibujin, taih, dayu, ish, wan, khan, günwan, beil, beis, taij, behi, beij, jonon, major, zangi, zaisan, zasag, chochur, hero, honjin, üizen, zelden, 28 titles, mostly from Chinese and Turkish languages, are marked, and religious titles include Dalai Lama, Bandida, Hamba, Tsorj, Lama, Toin, Hutagt, Güüsh, Gür, Tsorj, and Ubash which are mostly of Tibetan and Sanskrit origin., as well as arslan and zaan are marked as wrestlers.

Ном зүй

Баярсайхан, М. (2011) *Хаадын Үндэсний Эрдэнийн товч*, Улаанбаатар хот. [Bayarsaikhan, M. *Khaadiin undesnii Erdeniin tovch* [National Erdeniin tovch of Kings], Ulaanbaatar, Mönkhiin üseg printing, 2011.]

- Буяндэлгэр, Ж.** (1999) *Автай хаан ба Түмдийн Алтан хааны харьцаанаас халхын эртний түүхэн дэх хэдэн асуудлыг сэдэвлэх нь, Хөх хот, ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. [Buyandelger, J. Avtai khaan ba Tümdii in Altan khaanii kharitsaanaas khalkhiin ertnii tүүkhēn deh kheden asuudliig sedevlekh ni [Based on the relationship between Avtai Khan and Altan Khan of Tümed, wich studies some issues in the ancient history of Khalkh], Khökh khot, 1999.]
- Заяабаатар, Д.** (2011) *Асрагч нэртний түүх, Улаанбаатар*. [Zayabaatar, D. Asragch nertiin tүүkh, [History of Asragch nert]. Ulaanbaatar, 2011.]
- Сэцэнцогт.** (1988) *Монгол үгсийн язгуурын толь, Хөх хот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо*. [Setsentsogt, *Mongol ugsiin yazguuriin toli*, [Roots dictionary of Mongolian words]. Khukh khot, Övör Mongoliin ardiin khevleliin khoroo, 1988.]
- Цэвэл, Я.** (1966) *Монгол хэлний товч тайлбар толь*”, Улаанбаатар, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. [Tsevel, Ya. *Mongol khelnii tovch tailbar toli*, [Defining dictionary of Mongolian] Ulaanbaatar, Ulsiin khevleliin khereg erkhlekh gazar, 1966.]
- Шастиной, Н.П.** (1957) *ШАРА ТУДЖИ* Монгольская летопись XVII века, Ленинград. Издательство академи НАУК сср. [Shastinoi, N.P. SHARA TUJI Mongolian historical of the 17th century, Leningrad, USSR Academy of Sciences ptinting, 1957.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.